



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/46

Рашаант сум

**Мал, амьтны сэг зэм устгал,
халдваргүйтгэлийн ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3.3, 7.3.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 25-ны өдрийн А/122 тоот захирамж, Сумын Засаг даргын 2024 оны 04 сарын 08-ны өдрийн А/41 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Мал, амьтны сэг зэм устгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар Засаг даргын орлогч (Б.Идэр)-ийг томилсугай.
- 2.Мал, амьтны сэг зэм устгал халдваргүйтгэлийн ажлыг баг бүрт зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
- 3.Гол, горхи, мөрөнийг дагасан сав газарт хийх малын сэг зэм устгал, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлд хяналт тавих, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Билэгдэмбэрэл)-д даалгасугай.
- 4.Мал амьтны сэг зэм устгах ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Б.Идэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 2-ны өдрийн дугаар АНХ захирамжийн хавсралт

Д/д	Багийн нэр	Зохион байгуулах ажлын хэсэг	Албан тушаал	Хяналт тавих албан тушаалтан
1	Тээл баг	С.Далай	Багийн Засаг дарга	Б.Идэр-Засаг даргын орлогч
		Л.Батхуяг	БИНХ-ын хурал даргалагч	
		Э.Өлзийжаргал	Байгаль хамгаалагч	
		Г.Дархан-Очир	Малын эмч	
2	Талын-Ус баг	Б.Мөнхнасан	Багийн Засаг дарга	Т.Отгонцэцэг-ЗДТГ-ын дарга
		Б.Баттөмөр	БИНХ-ын хурал даргалагч	
		М.Билэгдэмбэрэл	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	
		Г.Дархан-Очир	Малын эмч	
3	Энхтал баг	П.Мөнхтүвшин	Багийн Засаг дарга	М.Билэгдэмбэрэл-Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
		Л.Баяржаргал	БИНХ-ын хурал даргалагч	
		Н.Отгончимэг	Байгаль хамгаалагч	
		Ч.Наранцэцэг	Малын эмч	
4	Цэнгэл баг	Б.Баянбаатар	Багийн Засаг дарга	Т.Отгонцэцэг-ЗДТГ-ын дарга
		Э.Лувсандэвгэ	БИНХ-ын хурал даргалагч	
		Г.Амаржаргал	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн	
		Ч.Наранцэцэг	Малын эмч	
5	Их-Ац баг	Д.Шинэбаяр	Багийн Засаг дарга	Б.Идэр-Засаг даргын орлогч
		Ж.Баясгалан	БИНХ-ын хурал даргалагч	
		Н.Отгончимэг	Байгаль хамгаалагч	
		Ц.Зоригт	Малын эмч	